



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 04

Чингис хот

┌ Нөөцийн сангаас нэр дэвшүүлэх тухай ┐

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.8, 2.3, 2.3.5, 2009 оны 99 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.1, 6.2, 6.2.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1 дэх заалтаар төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн Довжоогийн Баттулгыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтний сул ажлын байранд санал болгосугай.

2. Д.Баттулгыг сул ажлын байранд томилсон шийдвэрийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны дотор хүлээн авч танилцуулахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Болормаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР